



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 7/197

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1, 33.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэр Эсбагийн урд талд 200 метр квадрат газрыг аймгийн Засаг даргын Тамгын газарт /9068015/ сүү борлуулах цэг байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх нь баталгаажсан төсөвт байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

